



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/910

Мандалговь

“Малын түүвэр судалгаа”-ны  
аймгийн комисс байгуулах тухай

Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1. “в” дэх заалт, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Малын түүвэр судалгаа”-г зохион байгуулах аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Комиссын дарга:	Ц.Мөнхбат	( Аймгийн Засаг дарга )
Нарийн бичгийн даргаар:	Б.Энхтуяа	(Статистикийн хэлтсийн дарга )
Гишүүд:	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсийн дарга)
	Б.Мөнхжаргал	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
	Т.Бямбасүрэн	(Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
	Н.Давааням	(Статистикийн хэлтсийн мэргэжилтэн)

2. Комиссын гишүүд нь тухайн шатны онцгой комиссоос өгсөн заавар зөвлөмжийг мөрдөж, малын түүвэр судалгааны үед халдвар хамгаалалтын дэглэмийг сайтар сахиж, мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 06 дугаар сарын 15-наас 19-ний хооронд зохион байгуулан, хяналтын тооллого хийж, дүн мэдээллийг хугацаанд нь хүлээлгэн өгөхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. “Малын түүвэр судалгаа”-г засаг захиргааны нэгжид зохион байгуулахад шаардлагатай заавар зөвлөмжийг өгч судалгааг нэг зэрэг эхлүүлж, хугацаанд нь дуусгах, хяналтын тооллого явуулах, тооллогын шивэлт, дүнг эцэслэн боловсруулж Үндэсний Статистикийн хороонд заасан хугацаанд мэдээлэхийг Нарийн бичгийн дарга (Б.Энхтуяа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210575